

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дэмбэрэлдоо	Дугаар	L264
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Бүрэн сум
Төрсөн газар	Бүрэн сум	Төрсөн он	1912
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Оргиочийн хийд	Сүм хийдийн дугаар	ТӨЭС 004
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны10-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Мөнхбат

### Төв аймгийн Эрдэнэсант сумын Оргиочийн хийдийн тухай

Мөнхбат: За манай судалгааны баг одоогоос хоёр хоногийн өмнө одоогийн Төв аймгийн Эрдэнэсант сумын нутагт байх Оргиоч нуурын ард байх Оргиочийн хурлын тухай мэдээллийг аваад тэр Оргиочийн хурлын туурь дээр очиж тэнд очиж зураг авалт хийж, хэмжилт хийсэн. Тэгэхээр энэ хийдийн тухай одоо мэдэх хүн олдоогүй учраас хоёр хоногийн дараа буюу энэ Бүрэн сумын төв дээр эдүгээ нас сүүдэр 95 насыг зооглож байгаа Оргиочийн хийд дээр шавилж сууж байсан Дэмбэрэлдоо гуайтай уулзаж дараах ярилцлагыг авсан юм аа. Тэгэхээр энэ Оргиочийн хийд бол 1970-аад оны үед тодорхойлогдсон, Ренчин гуайн жагсаалтанд ороогүй, ийм дурдагдаагүй хурал номын газар.Бид нар Эрдэнэсант сумын төв дээрээс энэ газрыг хүнээр заалгаж шинээр бүртгэж авсан юм. Ингээд тэнд сууж байсан, шавилж байсан өндөр настан Дэмбэрэлдоо гуайтай уулзаж энэ ярилцлагыг хийхээр шийдвэрлэсэн.Тэгэхээр та Оргиочийн хийдэд хэдэн настайгаасаа суув, хэдэн настайдаа шар шувталж хар болж байсан бэ гэдгээс ярилцлагаа эхлэе?

Дэмбэрэлдоо: Би 6 настай очсон юм аа, лам болох гээд. Тэгээд бариа тавианы жил гарч ирсэн.

Мөнхбат: Тэгэхээр энэ Оргиочийн хийдэд таныг шавилж байх үед хичнээн лам хурдаг байсан юм, ямар ямар ном хурдаг байсан юм, хичнээн дуган байсан юм бэ?

Дэмбэрэлдоо: Гомбо сахиусыг тахиж байсан газар даа, ганжуур данжуур их л хурж байсан. Данжуурын дуган гэж байсан, ганжуурын дуган гэж байсан. Гол дуган гэж байсан даа. Лам нар нь чухам хэд байлаа даа.

Мөнхбат: Цам майдар гэж гардаг байсан уу?

Дэмбэрэлдоо:Цам гараагүй, майдар эргэж байсан юм.

Мөнхбат: Жас сангийн хувьд ямархуу байсан ?

Дэмбэрэлдоо: Овоо хөрөнгөтэй байсан.2 жастай байсан юм даа.

Мөнхбат: Хамгийн сүүлчийн хамба лам нь ямар хүн байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дэмбэрэлдоо: Даа лам багш гэж байсан юм.

Мөнхбат: Лам нараас хэлмэгдүүлэлтэнд хэр олон хүн баривчлагдсан бэ?

Дэмбэрэлдоо: Нэлээн олон лам нар л баригдсан.

Мөнхбат: Амьд эргэж ирсэн хүн бий юу?

Дэмбэрэлдоо: Мэдэхгүй ээ.

Мөнхбат: Хийдийн сүм дуган хэдий үе хүртэл байж байгаад нураагдсан юм?

Дэмбэрэлдоо: Мэдэхгүй ээ, би ерөөсөө санахаа байсан.

Мөнхбат: Том том эрдэм чадалтай лам нар ямар ямар хүн байсан юм бол?

Мөнхбат: Сономдорж гэж байсан, Сономпэлжээ гэж байсан. Гэлэнхүү гавж гэж байсан. Өвгөнхүү гавж гэж байсан. Манай багш байсан даа, даа лам багш гэж байсан. Эмч хүн байсан, манай багш бол.

Мөнхбат: Оргиочийн хийд дээр энэ Мишиг гүний хүрээ, Төвхөн хийд энэ тэртэй ямар холбоотой байсан юм бол, ном энэ тэр хаялцаж?

Дэмбэрэлдоо: Мэдэхгүй ээ, Есөн бүлгийн хүрээтэй л харлцаатай байсан байх. Дэлгэрхаантай нээх харилцаагүй байсан байх. Манай сүмтай л харилцаатай байсан байх.

Мөнхбат: Энэ сүм хийд хаагдахад доторх бурхан тахил, ном судар ямар замаар хаашаа явсан бэ?

Дэмбэрэлдоо: Мэдэхгүй.

Мөнхбат: Шатааж устгаж байсан уу, хураагаад авч явсан уу?

Дэмбэрэлдоо: Мэдэхгүй.

Мөнхбат: Оргиочийн хийдийн гол шүтээн сахиус нь ямар бурхан байсан бэ?

Дэмбэрэлдоо: Гомбо сахиустай байсан юм.

Мөнхбат: Оргиочийн хийд энэ байнгын хуралтай байсан юм болов уу, цагийн хуралтай байсан юм болов уу?

Дэмбэрэлдоо: Байнгын хуралтай байсан юм.

Мөнхбат: За баярлалаа.